



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/1151

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 14/01 тогтоол, аймгийн “Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдын авьяас, чадвар, эх хэл, түүх, соёл, өв уламжлал, шинжлэх ухааны мэдлэг чадварыг ахиулан хөгжүүлэх зорилгоор “Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын даваа”-г аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Улсын төрөлжсөн олимпиадыг зохион байгуулахад шаардагдах 19,278,850 (арван есөн сая хоёр зуун далан найман мянга найман зуун тавин) төгрөгийг аймгийн Засаг даргын “Шинэ ирээдүй” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3.Олимпиадыг зохион байгуулах арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

